



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/608

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Олон улсын ахмадын өдөр”-ийг угтан аймгийн бүх сумдын 1000 ахмадуудыг оролцуулан зохион байгуулах “Ахмадууд дуулж байна” дуун цэнгүүний үйл ажиллагааны зардалд 7 700 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 7 700 000 төгрөг /Долоон сая долоон зуун мянган/ -ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5. 23-д тусгагдсан “Ахмадаа ачлая” дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/608 Ch

02 03011

Аймгийн Засаг даргын 2019 оны 9 дүгээр
сарын 18- ны өдрийн А/608 дугаар
захирамжийн хавсралт



“ОЛОН УЛСЫН АХМАДЫН ӨДӨР*-ИЙГ УГТАН АЙМГИЙН БҮХ СУМДЫН 1000
АХМАДУУДЫГ ОРОЛЦУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ “АХМАДУУД ДУУЛЖ БАЙНА”
ДУУН ЦЭНГҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Дуун цэнгүүнийг зохион байгуулах зардал	Монгол улсын Ардын болон гавьяат жүжигчдын багийн тоглолт	Нийт тоглолт, үйл ажиллагааг зохион байгуулах баг	4 500 000
2	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх	1000	3200	3 200 000
	Нийт			7 700 000

-оОо-